

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/199/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн Захирал: О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН 7 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.ТӨГССАЙХАН ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/199/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 89,4 хувьтай тайлагнагдсан байна.

Хоолны зардал 14,962.6 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 30,420.8 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 29,849.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг нь сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа

байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар тус бодлогын баримт бичигт нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус цэцэрлэг нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



**Ч.ЭНХТУЯА**

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>59,416,725.92</b>	<b>109,432,587.56</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	22,695,007.69	74,849,324.13
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	22,695,007.69	74,849,324.13
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	22,695,007.69	74,849,324.13
31211	Төрийн сангийн харилцах	22,695,007.69	74,849,324.13
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,721,718.23	34,583,263.43
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,721,718.23	34,583,263.43
35410	Бичиг хэргийн материал	252,000.00	-
35420	Аж ахуйн материал	35,612,392.23	31,341,909.43
35460	Хүнсний материал	666,660.00	3,050,688.00
35470	Бусад хангамжийн материал	190,666.00	190,666.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,357,455,786.53</b>	<b>2,269,540,059.68</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,357,455,786.53	2,269,540,059.68
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,314,814,786.57	2,227,024,059.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,942,395,092.04	1,942,395,092.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,353,747.16)	(107,114,492.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,864,831.72	65,864,831.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,645,442.65)	(55,139,941.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,317,357.54	24,317,357.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,730,377.86)	(13,146,875.04)
39209	Зам, гүүрийн байгууламж	142,017,443.00	153,517,443.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(18,840,926.28)	(25,170,539.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	323,220,217.99	323,220,217.99
39215	Хуримтлагдсан элэгдэл	(51,595,022.77)	(83,884,395.01)
39217	Ном	2,165,361.00	2,165,361.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	42,640,999.96	42,516,000.00
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(125,000.04)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	42,516,000.00	42,516,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,416,872,512.45</b>	<b>2,378,972,647.24</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>949,708.78</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	949,708.78
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	949,708.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	73,208.78
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	876,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	876,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,416,872,512.45</b>	<b>2,378,022,938.46</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,416,872,512.45	2,378,022,938.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	430,890,181.10	430,890,181.10
51101	Өмч:- төрийн	430,890,181.10	430,890,181.10
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,905,717,455.82	1,866,867,881.83
51210	Өмнөх үеийн үр дүн	(511,155,056.63)	1,905,717,455.82
51220	Тайлант үеийн үр дүн	2,416,872,512.45	(38,849,573.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,264,875.53	80,264,875.53
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,416,872,512.45</b>	<b>2,378,972,647.24</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,036,646,729.87</b>	<b>698,774,368.82</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,495,325,223.65</b>	<b>15,491,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,495,325,223.65	15,491,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үх	2,456,646,408.42	11,500,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	38,378,815.23	3,991,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541,321,506.22</b>	<b>683,283,368.82</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	438,107,400.00	612,177,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	438,107,400.00	612,177,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	103,214,106.22	71,106,068.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,214,106.22	71,106,068.82
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>619,774,217.42</b>	<b>737,623,942.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>619,774,217.42</b>	<b>737,623,942.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	619,774,217.42	737,623,942.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	357,967,285.66	446,632,727.55
210101	Үндсэн цалин	270,527,868.82	258,441,028.05
210102	Нэмэгдэл	79,278,936.39	172,427,492.47
210104	Урамшуулал	8,160,480.45	15,764,207.03
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,174,990.87	55,372,667.99
210201	Тэтгэврийн даатгал	30,402,685.31	37,906,922.03
210202	Тэтгэмжийн даатгал	3,576,786.67	4,459,637.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,861,429.12	3,567,710.27
210204	Ажилгүйдлийн даатгал	652,305.73	832,023.87
210205	Эрүүл мэндийн даатгал	6,681,784.04	8,606,373.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49,903,644.50	62,114,018.82
210301	Гэрэл, цахилгаан	45,553,644.50	58,804,518.82
210303	Цэвэр, бохир ус	4,350,000.00	3,309,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	8,333,482.80
210408	Бараа материал акталсны зардал	-	8,333,482.80
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	36,687,224.50	40,214,004.00
210502	Хоол, хүнс	36,687,224.50	40,214,004.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,495,460.00	8,992,050.00
210604	Урсгал засвар	15,495,460.00	8,992,050.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	582,000.00	895,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,000.00	895,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	114,963,611.89	115,069,491.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,128,490.00	9,995,794.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,644,500.00	5,657,970.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,190,621.89	99,415,726.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,416,872,512.45</b>	<b>(38,849,573.99)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,416,872,512.45</b>	<b>(38,849,573.99)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>541,621,506.22</u></b>	<b><u>683,283,368.82</u></b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	300,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541,321,506.22</b>	<b>683,283,368.82</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	438,107,400.00	612,177,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	438,107,400.00	612,177,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	103,214,106.22	71,106,068.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,214,106.22	71,106,068.82
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>518,926,498.53</u></b>	<b><u>631,129,052.38</u></b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	518,926,498.53	631,129,052.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,926,498.53	631,129,052.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,967,285.66	446,597,894.59
210101	Үндсэн цалин	270,527,868.82	298,655,844.59
210102	Нэмэгдэл	79,278,936.39	132,177,842.97
210104	Урамшуулал	8,160,480.45	15,764,207.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,174,990.87	55,334,292.17
210201	Тэтгэврийн даатгал	30,402,685.31	37,876,807.90
210202	Тэтгэмжийн даатгал	3,576,786.67	4,456,095.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,861,429.12	3,564,875.99
210204	Ажилгүйдлийн даатгал	652,305.73	831,852.54
210205	Эрүүл мэндийн даатгал	6,681,784.04	8,604,660.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,903,644.50	62,114,018.82
210301	Гэрэл, цахилгаан	45,553,644.50	58,804,518.82
210303	Цэвэр, бохир ус	4,350,000.00	3,309,500.00
2105	Нормативт зардал	37,277,327.50	41,721,532.00
210502	Хоол, хүнс	37,277,327.50	41,721,532.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,495,460.00	8,992,050.00
210604	Урсгал засвар	15,495,460.00	8,992,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	582,000.00	895,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,000.00	895,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,525,790.00	15,473,764.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,995,790.00	12,494,294.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,530,000.00	2,979,470.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>22,695,007.69</u></b>	<b><u>52,154,316.44</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	22,695,007.69	52,154,316.44
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	22,695,007.69
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	22,695,007.69	74,849,324.13

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	430,890,181.10	80,264,875.53	(511,155,056.63)	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	430,890,181.10	80,264,875.53	(511,155,056.63)	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	2,416,872,512.45	2,416,872,512.45
8	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	430,890,181.10	80,264,875.53	1,905,717,455.82	2,416,872,512.45
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	430,890,181.10	80,264,875.53	1,905,717,455.82	2,416,872,512.45
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(38,849,573.99)	(38,849,573.99)
17	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	430,890,181.10	80,264,875.53	1,866,867,881.83	2,378,022,938.46

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	705,978,368.82	631,129,052.38	74,849,316.44	89.4
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	705,978,368.82	631,129,052.38	74,849,316.44	89.4
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	705,978,368.82	631,129,052.38	74,849,316.44	89.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	499,248,100.00	446,597,894.59	52,650,205.41	89.5
210101	Үндсэн цалин	328,073,700.00	298,655,844.59	29,417,855.41	91.0
210102	Нэмэгдэл	154,796,600.00	132,177,842.97	22,618,757.03	85.4
210104	Урамшуулал	16,377,800.00	15,764,207.03	613,592.97	96.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,406,500.00	55,334,292.17	7,072,207.83	88.7
210201	Тэтгэврийн даатгал	42,436,400.00	37,876,807.90	4,559,592.10	89.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,992,700.00	4,456,095.10	536,604.90	89.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,994,200.00	3,564,875.99	429,324.01	89.3
210204	Ажилгүйдлийн даатгал	998,400.00	831,852.54	166,547.46	83.3
210205	Эрүүл мэндийн даатгал	9,984,800.00	8,604,660.64	1,380,139.36	86.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62,114,018.82	62,114,018.82	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	58,804,518.82	58,804,518.82	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,309,500.00	3,309,500.00	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	56,684,100.00	41,721,532.00	14,962,568.00	73.6
210502	Хоол, хүнс	56,684,100.00	41,721,532.00	14,962,568.00	73.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,992,050.00	8,992,050.00	-	100.0
210604	Урсгал засвар	8,992,050.00	8,992,050.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	993,400.00	895,500.00	97,900.00	90.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	993,400.00	895,500.00	97,900.00	90.1
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,540,200.00	15,473,764.80	66,435.20	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,560,000.00	12,494,294.80	65,705.20	99.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,980,200.00	2,979,470.00	730.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	705,978,368.82	683,283,368.82	22,695,000.00	96.8
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	612,177,300.00	612,177,300.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	612,177,300.00	612,177,300.00	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	71,106,068.82	71,106,068.82	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	71,106,068.82	71,106,068.82	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	22,695,000.00	-	22,695,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	22,695,000.00	-	22,695,000.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	22,695,007.69	(22,695,007.69)	-

5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	74,849,324.13	(74,849,324.13)	-
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-	-	-
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	33	31	-	93.9
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	15	-	88.2
620003	Үйлчлэх ажилтан	15	15	-	100.0
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	151	120	-	79.5
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	1	1	-	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1	-	100.0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	33	31	-	93.9
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15	13	-	86.7
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	17	-	100.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд бүрд сурах тэгш боломжийг бүрдүүлж, сургалт үйл ажиллагааг чанартай зохион байгуулах, хүүхэд багшийн тасралтгүй хөгжлийг хангахад хамтарч ажиллана” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг харгалзан, тэдэнд амжилттай сурах тэгш боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан олон хэлбэрт ажлыг зохион байгуулах “чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнсээр хангах, зөв зохистой хооллох дадал хэвшилд сургах
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээг эв эеийг эрхэмлэн, хамт олноороо харилцааны эерэг хандлага соёлыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллах
- Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, хамтарч ажиллах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэгдэн батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
  1. *“ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”,*
  2. *“Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,899.9 мянган төгрөгөөр буюу 1,57 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	22,695.01	74,849.32	52,154.32
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,721.72	34,583.26	(2,138.45)
Үндсэн хөрөнгө	2,357,455.79	2,269,540.06	(87,915.73)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,416,872.51</b>	<b>2,378,972.65</b>	<b>(37,899.87)</b>
Өр төлбөр	-	949.71	949.71
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,416,872.51	2,378,022.94	(38,849.57)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,416,872.51</b>	<b>2,378,972.65</b>	<b>(37,899.87)</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Тайлант онд Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр 52,154.3 мянган төгрөг тайлагнасан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,269,540.0 мянган төгрөг болж 87,915.7 мянган төгрөгөөр буурсан нь Дэлхийн зөн ОУБ-ын хөрөнгө оруулалт 11,500 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авч, 99,415.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 624,461 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 103,500 мянган төгрөгөөр, нийт 727,961 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 103,286.1 мянган төгрөгийг бууруулж 521,174.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 103,500 мянган төгрөгөөр нийт 624,674.9 мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар 2023 оны 1,2,4,6,8,9,10,12-р саруудад нийт 8 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвийн санхүүжилтийг 113,697.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 634,872.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 32,393.9 мянган төгрөгөөр бууруулж нийт 71,106 мянган төгрөг нийт **705,978.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 595,227.6 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 72,105.6 мянган төгрөг нийт 667,333.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 549,156.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 705,978.4 мянган төгрөг буюу 89.4 хувьтай байгаа нь хоолны зардал 14,962.6 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 30,420.8 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 29,849.3 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
	Улсын төсвөөс санхүүжих				
1	81605 - Эрүүл мэндийг дэмжих	1,525.10	1,525.10	-	100.0
2	81605 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	56,684.10	41,721.53	14,962.57	73.6
3	81816 - Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	3,104.40	3,080.00	24.40	99.2
4	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,810.10	1,787.20	22.90	98.7
5	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	345,782.90	315,362.13	30,420.77	91.2
6	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	225,965.70	196,547.02	29,418.68	87.0
	<b>Дүн</b>	<b>634,872.30</b>	<b>560,022.98</b>	<b>74,849.32</b>	<b>88.2</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих				
7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	71,106.07	71,106.07	-	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>705,978.37</b>	<b>631,129.05</b>	<b>74,849.32</b>	<b>89.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ 56,684.1 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Тодруулбал мах, хүнсний материалыг Галил этоос ХХК, Ундрах тум ХХК, Цахим ертөнц ХХ, Алтан тариа ХХК, Хэрсэн чулуу ХХК, Эко наран гэрэлт ХХК, Түвшинсэлэнгэ ХХК, иргэн С.Майнбаяр, О.Цэрэнпагма, Д.Мөнхцэцэг, Ц.Оюун-эрдэнэ нартай тус тус гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 619,774.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,197.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 27 төрлийн 170 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон мэдээллүүд:

- Дараа жилийн төсвийн төсөл
- Худалдан авах ажиллагааны тайлан
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Оруулаагүй мэдээллүүд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /тайлбар оруулаагүй/

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгөгдсөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу тус цэцэрлэгийн нягтлан бодогч Б.Даваанямд хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 56,684.1 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”,

48 дугаар зүйлийн 48.5-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1. Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: *Бараа-70.0 сая төгрөг*, 2. “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: *Бараа-20.0 сая төгрөг*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах, хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус цэцэрлэгийн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус цэцэрлэгийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,022.1	1	3,022.1	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3,022.1</b>	<b>1</b>	<b>3,022.1</b>	<b>100</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит

гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **949.7** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч албан шаардлага өглөө.

### 5.1 Албан шаардлага

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ХХОАТ-ын 73.2 мянган төгрөгийн, хоолны зардлын 876.5 мянган төгрөгийн зэрэг нийт 949.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

#### 1. Цалин хөлстэй холбоотой

Илрүүлэлт: Сүхбаатар сумын 6 дугаар сургуулийн үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй Б.Даваанямыг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 100.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг зөрчсөн байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7: "Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх....",
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина",
- 84 дүгээр зүйлийн 84.4 дэх "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" зэрэг.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** 2 байгууллагад зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Өр төлбөр үүсгэсэн	1	949.7					1	949.7					
Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан	1						1						
Дүн	2	949.7					2	949.7					

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансанд мэдээлбэл зохих 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.	1							1				

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	
<b>Нийт дүн</b>	<b>2</b>				<b>1</b>		<b>1</b>	